

**БНХАУ ДАХЬ СИНЬЦЗЯН-УЙГУРЫН
АВТОНОМИТ РАЙОН**

М.Хурметхан

Синьцзян-Уйгурын автономит район (СУАР) нь 1955 оны есдүгээр сарын 30-нд албан ёсоор байгуулагдсанаас хойш эдүгээ 30 жил боллоо. Энэ хугацаанд Синьцзян дахь хятад биш үндэстнүүд амаргүй зам туулсан нь нийтэд тодорхой билээ.

1950-иад оны эхээр Синьцзян дахь хятад биш ард түмний өөртөө засан тогтнох асуудал хурцаар тавигдав. Синьцзян дахь уйгур болон хятад биш ард түмнүүд Хятадын хувьсгал ялж, БНХАУ байгуулагдсан явдлыг үндэстний асуудалд Хятадын удирдлага марксист-ленинист байр сууринаас хандаж, өөрсдөд нь үндэстний засан тохинох эрх олгоно гэсэн найдлага тавьж байв. 1951 оны эхээр Баруун хойт хятадын цэрэг засаг захиргааны хорооны дэргэдэх үндэстний хэргийг эрхлэх хороо Синьцзяны удирдах хариуцлагатай ажилтнуудад албан ёсоор хандаж синьцзяны үндэстний эрхийн талаар саналыг нь асуужээ. Синьцзяид уг асуудлыг албан ёсоор авч хэлэлцээд Синьцзяныг Уйгурын бүгд Найрамдах Улс өөрчлөн нэрлэж, уйгурын ард түмэн БНХАУ-ын хүрээнд үндэстний засаг төрөө байгуулах эрх олгох хүслээ илэрхийлжээ.

Гэвч энэ саналд Хятадын удирдлага эрс дургүйцэж дээрх саналыг илэрхийлсэн хүмүүсийг “үндэстний үзэлтэн”, хэмээн хардаж сэрдэн, баривчлах болжээ.

Иймэрхүү замаар Синьцзяид үндэстний засаг төр байгуулах гэсэн хүсэл эрмэлзлийг нухчин дарсны дараа хятадын эрх баригчид Синьцзяид “өөртөө засах” байгуулал байгуулахад шилжин орж, эхлээд засаг захиргааны доод нэгж, аймаг, хошуу, тойрог байгуулахаас эхлэн, дараа нь Уйгурын ард түмний өөртөө засан тохинох эрхийн асуудлыг орон нутгийн автономитор солив.

1955 онд байгуулагдсан СУАР-ын бүрэлдэхүүнд Казахуудын-Или казахын тойрог, Баркуль-Казах, Нори казахын хошуу, Киргизүүдийн Кизилсу-Киргизийн тойрог, Монголчуудын-Бортал Монгол, Баянгол-Монголын тойрог, Ховугсайр Монголын хошуу, Хотончуудын Чанцзы-Хотонгийн хошуу, Тажигчуудын Ташкуртан-Тажигийн хошуу, Шивээгийн-Чапчал-шивээгийн хошуу багтан орсон байна.

Ийнхүү уйгурчууд өөрийн автономит хэмжээг нийт Синьцзяны хэмжээгээр, казах, монгол, дунган автономит эрхийг тойрог, хошууны хэмжээнд киргизүүд автономит тойргийн хэмжээнд тажиг, шивээ нар автономит хошууны хэмжээнд тогтжээ. Үүнээс гадна СУАР-д уйгарчууд голлон амьдардаг Урумч, Кашгар, Хотон, Аксу тойрог оржээ.

СУАР байгуулагдсанаар тус район нь БНХАУ-ын засаг захиргааны нэгж төдий үлдэж, хятад биш ард түмнүүдийн үндэстний төр байгуулах эрхийг үгүйсгэн түүнийг зөвхөн орон нутгийн автономи гэгчээр хязгаарлав.

СУАР-ыг засаг захиргааны хувьд автономит нэгжид хуваахаас гадна тойрог, хошуу, район, гацаа гэж хуваасан юм. Энэ үед СУАР-д Или, Урумч, Тарбагатай, Алтай, Хами, Карашар, Хотон, Кашгар, Аксу, Яркенд гэсэн тойрогт хуваагдав. Тойрог тус бүр хошуунд хуваагджээ. Нийт 78 хошуутай байв.¹ Хошуу бүр гацаа (волость)-д хуваагдсан бөгөөд Синьцзянд 1958 онд 2284 гацаа байв.²

Синьцзян нь 1949 оныг хүртэл хэрэг дээрээ Хятадын газар тариалан-түүхийн эдийн хавсарга болж байв. Орон нутгийн хятад биш ард түмэн нь колоничлогчид болон орон нутгийн феодалуудын давхар дарлалд нэрвэгдэж байв. Энэ үед Синьцзяны эдийн засгийн гол үндэс нь хөдөө аж ахуй байсан учир түүнд шинэтгэл явуулах явдал чухал ач холбогдолтой байв. БНХАУ байгуулагдсаны дараа Синьцзянд хөдөө аж ахуйг хоршооллох хөдөлгөөн идэвхтэй явагдаж байв. 1956 оны эцэс гэхэд бүх тариачин өрхийн 93 хувийг багтаасан хөдөө аж ахуйн үйлдвэрийн 10700 хоршоолол байгуулжээ.³ Хоршооллын доод хэлбэрийг дээд хэлбэрт шилжүүлэн өөрчилж байгуулах ажил 1957 оны эцэс гэхэд шувтарч, дээд хэлбэрийн 5887 хоршоолол нь тариачны өрхийн 95.1 хувийг хамарчээ.⁴

Мал аж ахуйн районд төлөвлөсөн хугацаанаас нь хоёр жилийн өмнө тухайлбал 1958 онд 1716 хоршоололд 85 мянга орчим өрх нэгджээ.

Хоршооллыг яаравчлан байгуулж, сайн дурын зарчмыг зөрчсөн нь тариачид, малчдын дургүйцлийг төрүүлэн, хэд хэдэн газар тариачдын бослого хөдөлгөөн гаргахад хүргэв. Ялангуяа ХАЧА-ийн Үйлдвэрлэл-барилгын Корпус (ҮБК) гэгчид онцгой эрх мэдэл олгосон нь дээрх дургүйцлийн бас нэг шалтгаан байв. Учир нь Синьцзяны үр шимтэй, сайн бэлчээр 9,6 сая му газар, өөрөөр хэлбэл тус районы боловсруулж буй газрын гуравны нэгээс илүүг ҮБК-т өгсөн байна. Үүний хамт тэдгээр Корпусыг улсаас хөдөө аж ахуйн машин, мал сүрэг бордоогоор хангаж, тариачдын хоршоололд тийм тусламж үзүүлэхгүй байжээ.

ХКН-ын VIII их хурлын 1958 оны тавдугаар сарын бүгд хурлын шийдвэрийн дагуу “их үсрэлт”-ийн кампаныг Синьцзянд явуулсан нь хятад биш ард түмний ахуй амьдрал, эдийн засагт их хохирол учруулав.

1958 оны 7-р сард СУАР-ы намын хороо тус районд аж үйлдвэрийн 6122 газар байгуулах тухай зарлаж, ган, нүүрс, нефть үйлдвэрийг 1000 дахин нэмэгдүүлэхээр төлөвлөж байв. Ингээд 1958 оны намар Синьцзянд ширэм, ган хайлуулахад 1 сая хүнийг дайчлав.

1958 оны ес, аравдугаар сард 5800 хөдөө аж ахуйн хоршооллыг 500 коммун⁶ болгон өөрчлөв. Коммун тус бүр дундаар 800-6000

¹ К.Ф.Котов. Местная национальная автономия в КНР М., 1959 с 85.

² “Или газеты” 1956 IX.6

³ “БНХАУ үндэсний районууд дахь маогийнхны их гүрний бодлого” УБ, 1978. 60-р тал

⁴ Мөн тэнд

⁵ Национальный вопрос в Китае М., 1971.с.70

⁶ Г.Бахамов. Последствия “Коммунизации” в СУАР (1958-1960) Известия АН КазССР. Серия общественная, 1970. № 5, стр 39

тариачны өрхийг нэгтгэж, 50 мянган му газартай байв. Мал аж ахуйн районуудад коммун тус бүр 500-1300 өрхийг нэгтгэн 65-78 мянган толгой малтай байв.⁷ Коммун нь урьдах хөдөө аж ахуйн хоршооллоос аж ахуйг хөтлөх арга, хөдөлмөр зохион байгуулах, орлогыг хуваарилах, нийгэмчлэх байдлаараа эрс ялгаатай байв.

Коммуныг зохион байгуулагчид хувийн өмчийн эцсийн үлдэгдэл гээд тариачдын амины аж ахуйд байсан цэцэрлэг, мал гэр ахуйн хэрэгсэл зэргийг нийгэмчилжээ.

Хятадын эрх баригчдын энэ нугалаа нь Синьцзяны хүн амын аж амьдралд их хор уршиг тарив. СУАР-ы хөдөө аж ахуй сүйрлийн ирмэгт тулж, олон зуун мянган хүний амь насыг хөнөөхөд хүргэсэн өлсгөлөн эхлэв.

Эл байдал нь яаралтай арга хэмжээ авахыг шаардав. 1961 оны нэгдүгээр сард хуралдсан ХКН-ын ТХ-ны IX бүгд хурал эдийн засгийн “Зохицуулах” чиг шугам боловсруулав. “Зохицуулах” бодлогын явцад “ардын коммуны” адал балмад чиг шугамаас ухарч хөдөлмөрийг зохион байгуулах хуучин арга хэлбэрт дахин эргэж оров. Тариачны газрыг буцаан олгож, үнэ төлбөргүй хооллох журмыг өөрчлөн, хувийн аж ахуйд мал, шувуу өсгөхийг зөвшөөрөн, амины аж ахуйг сэргээв.

Мао Цзедуны коммунчилах бодлого нь Синьцзянд үндэстний асуудлыг хурцатгав. Хятадын эрх баригчдын бодлого, их гүрний дээрэнгүй үзлийг хэрэгжүүлэхийг эсэргүүцэгчдийг “орон нутгийн үндэстний үзэлтэн” гэж нэрлэн, залхаан цээрлүүлж, СУАР-д орон нутгийн ард түмнийг хятадчилах, ялгаварлан гадуурхах бодлого хүчтэй болов.

1958, 1959 оноос СУАР-д Хятадын төвийн районоос олон мянган хятад хүмүүсийг суурьшуулах болов. Үүний улмаас хятад хүмүүсийн тоо эрс нэмэгдэн 1949-1966 оны 3 хувиас 45 хувь болтол нэмэгдэв.⁸ Хятад хүмүүс олноор ирж суурьшсан нь СУАР дахь хятад биш ард түмнийг уусган хятадчилах нөхцөлийг бүрдүүлэв.

Синьцзян дахь Мао Цзедуны их гүрний дээрэнгүй чиг шугам нь орон нутгийн хүн амын эрс дургүйцлийг хүргэсэн юм. Энэ онуудад Синьцзянд олон тооны бослого гарав. Тэдгээр бослого, түүний дотор 1962 онд гарсан нефтийн үйлдвэрүүдийн ажилчдын бослогыг цус урсган дарж байв.

Маогийнхны бодлогыг орон нутгийн ард түмний эсэргүүцэх өөр нэг хэлбэр нь хөрш зэргэлдээ орнуудад олноор дүрвэн гарч байсан явдал юм. Энэ үед СУАР-аас олон хүн ЗХУ, Афганистан зэрэг оронд дүрвэн гарчээ. 1949-1966 онд СУАР-аас 200 мянган орчим хүн ЗХУ-д гарсан мэдээ бий.⁹

СУАР-д “соёлын хувьсгал” Бээжингээс 700 “улаан хамгаалагчид” ирснээр эхлэв. Тэд эхлээд “дөрвөн хуучин” (хуучин заншил, зуршил, соёл, ёс суртахуун)-ыг устгах хөдөлгөөн өрнүүлэв. Энэ хөдөлгөөн нь практик дээр зүй бус зоргоороо аашлах, танхай балмад үйлдэл байв.

⁷ Г.Бахамов. Последствия “Коммунизации” в СУАР (1958-1960) Известия АН КазССР. Серия общественная, 1970. № 5, стр 39

⁸ Национальный вопрос в Китае. М, 1971, стр 47.

⁹ Национальный вопрос в Китае. М, 1971, стр 49.

“Улаан хамгаалагчид” уйгур болон хятад биш бусад ард түмний соёл, урлагийн дурсгалыг эвдэн сүйтгэж, үндэстний зан заншил, уламжлалаар тоглоом тохуу хийж, орон нутгийн ард түмний хэлээр бичигдсэн ном зохиолыг шатааж байв. Тухайлбал, Урумч хотын эртний гар бичмэлийн музейг устгажээ. Синьцзяны хятад биш ард түмний нэрт хүмүүс, зохиолчид, урлагийн ажилтнууд нийгмийн бүх анги бүлгийнхний төлөөлөгчдийг залхаан цээрлүүлж, жанчин доромжилж байв. “Улаан хамгаалагчид” залхаан цээрлүүлэх 60 гаруй аргыг хэрэглэж байв.¹⁰

1966 оны 9-р сарын сүүлчээр орон нутгийн олонх удирдагчид, түүний дотор намын хорооны нарийн бичгийн дарга Ван Эньмао “улаан хамгаалагчдын” ширүүн дайралтын бай болов. Удалгүй “улаан хамгаалагчид” СУАР-ы “Синьцзян жибао”, “Синьцзян газета” сонины редакцийг дайран эзэлж дараа нь СУАР-ы Намын хороо, Ардын хороог эзлэн авлаа.

Тус районд “хувьсгалт хороог” байгуулах асуудлаар удаан маргалдан олон мөргөлдөөн гарсны эцэст СУАР-ы “Хувьсгалт хороо” байгуулсан тухай Синьцзяны цэргийн тойргийн намын хорооны илтгэлийг 1968 оны есдүгээр сард ХКН-ын Төв Хороо, БНХАУ-ын Төрийн зөвлөл, ХКН-ын Төв хорооны дэргэдэх цэргийн зөвлөл, “соёлын хувьсгал” эрхлэх бүлэг сайшааж, СУАР-ы “хувьсгалт хорооны” даргаар генерал Дун Шуцзинь томилогдов. Түүний есөн орлогчийн дотор нэг уйгур (Сайфутдин Азизов), нэг казах (Зия) үлдсэн нь цөм хятад хүмүүс байжээ. Ийнхүү соёлын хувьсгал нь Синьцзяны орон нутгийн ёс төдий автономит эрхийг бүрмөсөн устгав.

1971 оны 5-р сараас СУАР-ы хувьсгалт хороо, намын хороог Сайфутдин Азизов толгойлох болов. Энэ үеэс магогийнхан Синьцзянд намын байгууллагыг сэргээж, түүнийг өөрсдийнхөө бодлогод ашиглахад эрмэлзэж эхлэв. Синьцзяны ард түмнүүдийн үндэстний уламжлалтыг хүндэтгэх” тухай дахин ярих болов. Энэхүү арга хэмжээ нь орон нутгийн ард түмний хүсэл эрмэлзэл, Бээжингийн их гүрний дээрэнгүй бодлогын зөрчлийг бага хэмжээгээр ч зөөлрүүлэхийг оролдсоны шинж байв.

Энэ үед автономит районы эдийн засгийг цэрэгжүүлэхэд үлэмж анхаарах болсон нь Бээжингийнхний баримталсан зөвлөлтийн эсрэг үзэлтэй холбоотой байлаа.

СУАР-д зөвлөлтийн эсрэг үзлийг дэврээхийг үлэмжхэн мэрийж байв. 1975 онд СУАР-ы байгуулагдсаны 20 илийг зөвлөлтийн эсрэг үзлийг хөөргөн дэвэргэхэд шууд ашиглаж байлаа.

СУАР-ы “стратегийн байрлал” гэгчийг Синьцзяныг ЗХУ-ын эсрэг цэрэг дайны түшиц газар болгон хувиргахад чиглэгдсэн шалтаг болгон ашиглаж байв. Нөгөө талаар тус районы нийгмийн амьдралыг бүхэлд нь цэрэгжүүлж байлаа. Энэ жилүүдэд маогийнхан Синьцзян дахь хятад биш ард түмнийг хятадчилах чиг шугамаа үргэлжлүүлж байсан боловч тус районд бий болсон бэрхшээлийг харгалзан үндэстний асуудлын талаар зарим өөр тактик хэрэглэж байв.

1976 онд Мао Цзедун нас барж “дөрвийн бүлгийг” авч хаясны дараа Хятадын эрх баригчид, үндэстний асуудлаар урьд баримталж байсан хятад биш ард түмнийг гадуурхаж, их хятад үндэстний дээрэнгүй үзлийн бодлогыг удаан хугацаанд явуулсан хариуцлагыг тэ-

¹⁰ А.Базылбаев “Анасапыраимен өткентөртжыл” А-А. 1980. 6.32

дэнд тохжээ.Тэднийг үндэстний асуудлын талаар “феодалын харгис фашист бодлого”¹¹ явуулсан гэж зэмлэж байв.

Сайфутдин Азизов СУАР-ы удирдлагад удсангүй. Түүнийг 1978 оны 2-р сард СУАР-ы хувьсгалт хорооны дарга болон бусад албан тушаалаас зайлуулав. СУАР-ы удирдлага дахь бүх албан тушаалыг хан үндэстний төлөөлөгч Ван Фэн авчээ. Үүний дараа ч тус районы хятад биш ард түмний байдалд өөрчлөлт гараагүй бөгөөд их гүрний үндсэрхэг үзлийг цаашид үргэлжлүүлж байлаа.

Тус районы эдийн засгийн байдал доройтон, хоол хүнс, эн тэргүүний хэрэгцээт зүйлээр, ялангуяа үндэстний хэрэгцээт бараагаар дутагдаж байв. Иймэрхүү байдал нь Синьцзян-уйгурын автономит районд байдалд улам хурцдахад хүргэв. 1981 оны 8-р сард байдал бүр дордож Дэн Сяопинийг энэ автономит районд очуулахад хүргэж бас Бээжингийн өөр нэг эрх баригч болох ХКН-ын Төв Хорооны улс төрийн товчооны гишүүн Ван Чжэнийг 1981 онд наад зах нь гурван удаа очиход хүргэжээ. Бээжинд эцсийн эцэст үндэстний районы удирдлагыг өөрчлөхөөр шийдвэрлэжээ. Ингээд хан үндэстэн Ван Эньмаог СУАР-ы намын хорооны дарга болгосон юм. Синьцзянд бүр “соёлын хувьсгалын” үед ажиллаж байсан Ван Эньмао хятад биш ард түмний эсэргүүцэл тэмцлийг зогсоож чадна гэж Бээжингийнхэн бодсон боловч тэр нь талаар болсон байна. Ван Эньмао Хятад биш ард түмний эсэргүүцэл тэмцлийг зогсоож чадна гэж бээжингийнхэн бодсон боловч тэр нь талаар болсон байна. Тус районд түгшүүртэй байдал хэвээр байгааг Ван Эньмао өөрөө хүлээн зөвшөөрч, гол зорилт бол улс төрийн тогтвортой байдлыг хангах, үндэстний эв нэгдлийг бэхжүүлэх асуудал гэж тэмдэглэж байв.

1983 оны III сард СУАР-ы намын хорооны нарийн бичгийн даргаар Ван Эньмао дахин сонгогдов. СУАР-ы намын хороо 15 хүнтэй болж, түрүүчээс 6 хүнээр цөөрчээ. Намын хорооны нарийн бичгийн дарга 6 хүний 3 (Исмайл Аймаг, Тимур Давамади, Жанабул) нь хятад биш үндэстний төлөөлөгч байна.¹²

СУАР-д шинэ засгийн газар байгуулсан тухай ХКН-ын Төв хэвлэл “Жэньминь жибао” сонин 1983 оны V сард мэдээлснээр СУАР-ы ардын төлөөлөгчдийн хурлын Байнгын хорооны даргаар Тимур Давамади (уйгур) автономит районы даргаар Исмайл Аймаг (уйгур)-ыг томилжээ. Синьцзяны ардын засгийн газрын 7 орлогчийн гурав нь Ардын төлөөлөгчдийн Хурлын Байнгын хорооны 13 орлогчийн 5 нь хятад хүн байна. Энэ нь тус районы хятад биш ард түмэн өөрийгөө удирдаж байгаа мэт ойлголтыг олон нийтэд өгч байгаа боловч үнэндээ хятадын эрх баригчдын үндэстний бодлогод үндсэн өөрчлөлт гарч буйн гэрч биш юм.

Сүүлийн жилүүдэд үндэстний районуудад үндэстний боловсон хүчнийг бэлтгэх, тэднийг дэвшүүлэх тухай яригдаж байна. Гэтэл 1981 онд СУАР-ы намын хорооны нэгдүгээр нарийн бичгийн дарга Ван Эньмао Синьцзянд “Үндэстний боловсон хүчнийг хэт дэвшүүлэх хэрэггүй”¹³ гэжээ. Энэ нь үндэстний боловсон хүчний талаарх бодлогод онцын өөрчлөлт ороогүй байгааг нотолж байна. Хятадын албан ёсны хэвлэлийн мэдээгээр 1983 оны байдлаар СУАР-ы 10 районд удирдлагын 44.4 хувь нь хятад ард түмний төлөөлөгчид байгаа ажээ.

“Соёлын хувьсгал”-ын үед бут цохигдсон СУАР-ы үйлдвэрчний байгууллага сэргээн байгуулагдав. Гэвч тэрнь хөдөлмөрчдийн эрх ашгийг

¹¹ Жэньминь жибао” 1978. х. 20,

¹² “Вань юэтань” 1983. № 8

¹³ “Үнэн” 1981. 1. 14

хамгаалах бодит боломжоор хангагдаагүй байна. Мөн СУАР-ы залуучуудын байгууллага, эмэгтэйчүүдийн байгууллагын ажил сэргэв. Бээжингийн удирдагчдаас үндэстний районууд, түүний дотор СУАР-д явуулж буй улс төрийн бодлогын гол нь “дөрвөн шинэчлэлтийг” хэрэгжүүлэхэд тус районы “нөөц баялаг, үндэстний идэвхтэй дэмжлэг”-ийг олоход чиглэгдэж байна. Чухамдаа үүнд анхаарч байгаа хятадын эрх баригчид сүүлийн жилүүдэд СУАР-д олонтаа очих болжээ. 1983 оны 5-р сард ХКН-ын Төв Хорооны ерөнхий нарийн бичгийн дарга Ху Яобан, 1983 оны 8-р сард БНМАУ-ын Төрийн Зөвлөлийн ерөнхий сайд Чжао Цзыян, ХКН-ын Төв Хорооны нарийн бичгийн дарга Ху Цили нар очиж, тус районы хувьд явуулж буй бодлогыг тайлбарлан ярьжээ.

ХКН-ын Төв Хорооны ерөнхий нарийн бичгийн дарга Ху Яобан 1983 оны 5-р сард СУАР-ы удирдах хүмүүс, цэргийнхэнтэй уулзаж хэлсэн үгэндээ “Синьцзян, цаашилбал баруун хойдих нутаг бол Хятад орныг хүчирхэг гүрэн болгоход чухал район юм. Ийм учраас түүнийг орчин үеийн социалист орны нэгэн том бааз болгон хувиргах асуудлыг нэн даруй шийдэх хэрэгтэй”¹⁴ гэжээ. Чжао Цзыян хэлэхдээ: “Синьцзян болон баруун хойд хязгаарыг нээн ашиглах нь ХКН-ын Төв Хорооны стратегийн чухал зорилт” гээд “одоогоос эхлэн Синьцзяныг бүх улсын бүтээн байгуулалтын хэлэлцэх хэргийн төлөвлөгөөнд оруулах хэрэгтэй”¹⁵ гэсэн байна.

Ийнхүү Хятадын эрх баригчид тус автономит районы “стратегийн байрлалыг” онцлон чухалчилж байв. Ху Яобан Синьцзяныг “Хятадын хилийн хамгийн том район”¹⁶ гэж нэрлэснийг үүнтэй холбогдуулан дурдахад хангалттай юм. СУАР-ыг “баруун хойд хил хязгаарыг хамгаалах хүчирхэг цайз”¹⁷ гээд “гадаадын дайсны эсрэг онцгой сонор сэрэмжтэй байхыг” олонтаа уриалж, ингэснээр СУАР дахь хятад биш ард түмнийг их хятадын дээрэнгүй үзлийг эсэргүүцсэн тэмцлээс холдуулахыг бээжингийнхэн санаархаж байна.

Сүүлийн жилүүдэд Синьцзянд баримтлах үндэстний бодлогын талаар Хятадын эрх баригчид нэлээд ярьж байна. “Синьцзян бол олон үндэстнүүдийн нутаг юм. Иймд намаас үндэстнүүдийн талаар явуулж байгаа бодлогыг нэвтрүүлж, бүх үндэстнүүдийн дунд нэгдэл нягтралыг бэхжүүлэхийн тулд улам их арга хэмжээ авах хэрэгтэй”¹⁸ өөрөөр хэлбэл “эв нэгдлийг чангатгах” тэдний хооронд “загас усны харьцааг” тогтоох хэрэгтэй гэсэн сэдвийг олонтаа ярьж байна. Учир нь Ван Эньмаогийн хэлснээр Синьцзянд үндэстний асуудал “стратегийн” асуудал болж байгаа ажээ.

“Соёлын хувьсгал”-ын үед үндэстний асуудлаар баримталж байсан алдаатай бодлогыг зарим талаар гэтлэн давахыг хятадын удирдагчид оролдож байн. Үүнд: СУАР дахь хятад биш ард түмний эх хэлийг хэрэглэх, хэвлэн нийтлэх, уран бүтээл туурвих зэргийг зөвшөөрөв. СУАР-ы Ардын Төлөөлөгчдийн Байнгын хороо 1982 оны 9-р сараас уйгур, казах уламжлалт бичгийг сэргээн хэрэглэхээр болов. Их, дээд сургууль хичээллэх болж, зарим эрдэм шинжилгээний байгууллагууд шинээр байгуулагдав. 1982 оноос СУАР-ы зохиолчдын эвлэл ажлаа сэргээв.

¹⁴ “Жэньминь жибао” 1983. V. 21.

¹⁵ “Жэньминь жибао” 1983. IX. 23.

¹⁶ “Жэньминь жибао” 1983. V. 21.

¹⁷ “Жэньминь жибао” 1981. 10. 28.

¹⁸ “Чайна дейли” 1983. IX. 3.

Энэ бүхэн нь үндэстний асуудал СУАР-д шийдвэрлэгдсэн гэсэн хэрэг биш гэдэг нь тодорхой” БНХАУ-ын үндэстний районы автономийн хууль” нь хятад биш ард түмний хувьд чухал үйл явдал болжээ. Гэвч үндэстнүүдийн эрхийг зөвхөн орон нутгийн автономиаар хязгаарласан нь уг хуулиас тодорхой билээ. Нөгөө талаар СУАР-д хүн амын амьжиргааны байдал жигд сайжраагүй байна.

СУАР-д зарим хүмүүс трактор, мотоцикл, телевиз, магнитофон худалдан авч байгаа тухай мэдээлж буй нь цөөн тооны хүмүүсийн амьдралын жишээн дээр хэлж байгаа бөгөөд гэтэл дийлэнх олонхийн ахуй амьдрал нэг хэмжээндээ юмуу, зарим нь бүр ядуу зүдүү хэвээр байна.

1985 оны 10-р сарын 1-нд Урумч хотод СУАР байгуулагдсаны 30 жилийн ойг тэмдэглэв. Уг ажиллагаанд Пакистаны төлөөлөгчдөөс гадна ЗХУ-ын Казах, Узбек, Киргиз зэрэг Зөвлөлтийн Бүгд найрамдах улсын төлөөлөгчдийг урьж оролцуулав. СУАР дахь хятад биш ард түмнүүд автономит район байгуулагдсаны дараах түүхийн дөрөв дэх арван жилд шилжин орлоо.

Эдүгээ СУАР-ы хятад биш ард түмэн Хятадын удирдлагын үндэстний бодлогыг маш соргогоор хэрхэн яаж явагдахыг зүй ёсоор ажиглан харж байна.

СИНЬЦЗЯН-УЙГУРСКИЙ АВТОНОМНЫЙ РАЙОН В КНР

Резюме

Прошло 30 лет с момента когда 30 сентября 1955 года официально был создан Синьцзян-Уйгурский автономный район КНР. В статье автор пишет как не китайские национальности в синьцзяне испытала разные трудности в течение длительного времени. Китайские руководители в свое время отказались предоставить неханским народам района желаемое их право на самоопределение, а ограничили их лишь правом на местную автономию.

До 1949 года сельское хозяйство являлось основой экономики Синьцзяна и оно нуждалось в реформах.

В СУАР кооперация сельского хозяйства до середины 1955 года проходила в целом нормально. Однако в дальнейшем этот процесс был игнорирован.

Кампания “большого скачка”, выдвинутая майским пленумом VIII съезда КПК нанесла тяжелый ущерб жизни и экономике неханских народов Синьцзяна и усилила китаизацию его коренного населения.

“Культурная революция” в Китае явилась тяжелым ударом для неханских народов Синьцзяна и в большом количестве уничтожила их культурные наследия.

Милитаризация в широком масштабе экономики автономного района была тесно связана с антисоветским курсом китайского руководства в период “культурной революции”.

В 1976 году умер Мао Цзэдун и после уничтожения “банды четырех”, китайские руководители наложили на них всю ответственность

ность за неблагоприятную политику по национальному вопросу, обвинив их в прведении “феодално-фашистской реакционной политики”.

Китайские руководители в своих выступлениях и речах о национальной политике по отношению и СУАР главный акцент делают на использования природных ресурсов этого района для осуществления программы “4-х модернизаций”.

Китайские руководители также подчеркивают сейчас важность поощрения неханьских народов автономных районов КНР, включая СУАР, и исправления полностью прежней ошибочной политики в национальном вопросе.

В заключении статьи автор подчеркивает, что за прошедшие 30 лет неханьские народы СУАР вследствие политики китайского руководства испытали на себе немалые трудности и теперь они вправе ожидать, несколько продолжителен полезен будет проводимый им ныне курс в национальных районах КНР.